


**ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ**  
2019.04.29-05.03

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** АНУ-ын хөрөнгийн зах зээлийн S&P 500 болон Nasdaq индексүүд өссөн бол Dow Jones индекс буурсан үзүүлэлттэй байна. S&P 500 индексийн сагсанд багтдаг эрүүл мэндийн салбарын компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагдсан бол эрчим хүч, харилцаа холбооны салбарын компаниудын хувьцааны ханш буурлаа.

Эрүүл мэндийн салбарын “Merck” болон “CVS Health” компаниудын 2019 оны 1-р улирлын санхүүгийн тайлан гарч, эдгээр компаниудын нэгж хувьцааны ханш өсжээ. Харин АНУ газрын тосны гарц нэмэгдэх болсноор газрын тосны ханш буурч, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханшид сөргөөр нөлөөлжээ. Мөн “Google” компанийн толгой компани болох “Alphabet” компанийн хувьцааны ханш огцом буурч харилцаа холбооны салбарт нөлөөлжээ.

АНУ-ын Төв банкны Холбооны нээлттэй зах зээлийн хороо Мягмар, Лхагва гарагт хуралдсаны дүнд бодлогын хүүг 2.25-2.5 хувьд хэвээр үлдээх шийдвэр гаргажээ. АНУ-ын Төв банкны тэргүүн Жером Пауэлл “Одоогийн хэрэгжүүлж байгаа мөнгөний бодлого зохистой” гэж мэдэгдсэн юм. Түүнчлэн “Мөнгөний бодлогыг ойрын саруудад өсгөх, эсвэл бууруулах шаардлагагүй” гэж онцолжээ.

АНУ, БНХАУ-ын худалдааны асуудлаарх ээлжит уулзалт Бээжинд өндөрлөлөө. “Үр дүнтэй” уулзалт хийсэн гэж АНУ-ын Сангийн сайд Стивен Мнучин өөрийн “twitter” хуудастаа нийтэлсэн байна. Хэлэлцээ ирэх долоо хоногт Вашингтонд үргэлжлэх юм.

**Европ:** Европын бүсийн эдийн засаг удааширч байгаатай холобоотойгоор Европын хөрөнгийн зах зээлийн STOXX Europe 600 индекс буурч хаагдлаа.

Английн төв банк богино хугацаат бодлогын хүүний түвшиндээ өөрчлөлт оруулалгүй үлдээлээ. Ингэснээр Их Британийн FTSE 100 индекс буурч хаагдлаа. Мөн Их Британийн Ерөнхий сайд Тереза Мэй 5-р сарын 23-26-нд болох Европын Парламентын сонгуулиас өмнө BREXIT-ийн хэлэлцээрийн төсөлдөө дэмжлэг авахаар зорьж байна. Өмнө нь Парламентын санал хураалтаар гурван ч удаа няцаагдсан BREXIT-ийн хэлэлцээрийн төслийг улс орны эрх ашигт нийцээгүй гэж сөрөг хүчин шүүмжилж байгаа аж. Тиймээс Ерөнхий сайд Тереза Мэй сөрөг хүчинтэй хэлэлцсэн ч шийдэлд хүрээгүй юм.

Испанийн Парламентын сонгуульд ялалт байгуулсан Социалист намын дарга Луис Абало жижиг намуудтай Эвслийн Засгийн газар байгуулахгүй гэдгээ мэдэгдлээ. Тэрбээр “Гэрээ хэлэлцээрээр бус улс төрийн санал, хөтөлбөрөөр дамжуулан дэмжлэг авахыг эрмэлзэнэ” гэж онцолсон байна. Сонгуулиас 29 хувийн санал авсан Социалист намын хувьд Засгийн газар байгуулах нь гол асуудал биш ажээ. Харин 5-р сарын 26-нд болох Европын Холбооны сонгуульд оролцох нь чухал гэж үзэж байгаа юм байна.

**Эх сурвалж:** Troweprice.com, BloombergTv.mn

### Олон улсын индексүүд

| Индекс      | Улс        | Хаалт     | Өөрчлөлт |
|-------------|------------|-----------|----------|
| MSE TOP 20  | Монгол     | 20,393.27 | 0.80% ▲  |
| Dow Jones   | АНУ        | 26,504.95 | -0.14% ▼ |
| S&P 500     | АНУ        | 2,945.64  | 0.20% ▲  |
| Nasdaq      | АНУ        | 8,164.00  | 0.22% ▲  |
| S&P/TSX     | Канад      | 16,494.43 | -0.72% ▼ |
| FTSE 100    | Их Британи | 7,380.64  | -0.64% ▼ |
| S&P/ASX 200 | Австрали   | 6,335.80  | -0.78% ▼ |
| Nikkei 225  | Япон       | -         | 0.00%    |
| Hang Seng   | Хонг Конг  | 30,081.55 | 1.61% ▲  |

### Бондын өгөөж

| Бонд                   | Валют | Купон   | Үнэ    |
|------------------------|-------|---------|--------|
| Mongol 2024 (Хуралдай) | USD   | 8.750%  | 110.68 |
| Mongol 2023 (Гэрэгэ)   | USD   | 5.625%  | 98.79  |
| Mongol 2022 (Чингис)   | USD   | 5.125%  | 98.32  |
| Mongol 2021 (Мазаалай) | USD   | 10.875% | 110.36 |
| DBM' 23 (Самурай)      | JPY   | 1.520%  | 104.07 |
| DBM' 2023              | USD   | 7.250%  | 102.39 |
| TDBM' 2020             | USD   | 9.375%  | 103.70 |

### Зах зээлийн хүү

| Хүү          | Хаалт | Өөрчлөлт |
|--------------|-------|----------|
| Libor 1M     | 2.460 | -0.02 ▼  |
| Libor 3M     | 2.560 | -0.02 ▼  |
| Libor 6M     | 2.620 | 0.01 ▲   |
| Libor 1YR    | 2.750 | 0.03 ▲   |
| US 2YR Bond  | 2.333 | 0.05 ▲   |
| US 3YR Bond  | 2.300 | 0.05 ▲   |
| US 5YR Bond  | 2.323 | 0.04 ▲   |
| US 10YR Bond | 2.525 | 0.03 ▲   |

### Валютын ханш /төг/

| Валют | 2019.05.03 | Өөрчлөлт |
|-------|------------|----------|
| USD   | 2,641.58   | 0.08% ▲  |
| CNY   | 392.24     | 0.12% ▲  |
| EUR   | 2,949.32   | 0.31% ▲  |
| RUB   | 40.44      | -0.88% ▼ |
| KRW   | 2.26       | -0.44% ▼ |
| JPY   | 23.69      | 0.21% ▲  |
| CAD   | 1,961.67   | 0.17% ▲  |

### Түүхий эдийн үнэ

| Түүхий эд        | Хэмжих нэгж | Хаалт    | Өөрчлөлт |
|------------------|-------------|----------|----------|
| Алт /спот/       | USD/t oz.   | 1,279.11 | -0.55% ▼ |
| Мөнгө /спот/     | USD/t oz.   | 14.94    | -0.96% ▼ |
| Зэс              | USD/lb.     | 281.90   | -2.59% ▼ |
| Нүүрс            | USD/MT      | 88.35    | 2.00% ▲  |
| WTI газрын тос   | USD/bbl.    | 61.94    | -2.15% ▼ |
| Brent газрын тос | USD/bbl.    | 70.85    | -1.80% ▼ |
| Байгалийн хий    | USD/MMBtu   | 2.57     | 0.00%    |

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

| Үзүүлэлт                         | Хугацаа   | Хэмжээ |
|----------------------------------|-----------|--------|
| Инфляцийн түвшин                 | 2019. III | 6.70%  |
| Бодлогын хүү                     | 2019. III | 11.00% |
| Банк хоорондын зах зээлийн хүү   | 2019. III | 10.94% |
| Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/ | 2019. III | 12.06% |
| Хадгаламжийн дундаж хүү /валют/  | 2019. III | 4.93%  |
| Зээлийн дундаж хүү /төгрөг/      | 2019. III | 17.10% |
| Зээлийн дундаж хүү /валют/       | 2019. III | 10.60% |

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 49 компанийн 1,293.6 сая төгрөгийн 6,277,695 ширхэг хувьцаа арилжигдав.


“МИК Холдинг” /MIK/ компанийн хувьцаа 23.69%-аар буюу хамгийн ихээр өсөж 14,200.0 төгрөгт хүрч хаагдсан бол “УБ-БҮК” /BUK/ компанийн хувьцаа 17.11%-аар буурч 315.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 20,100 ширхэг үнэт цаас 20,010.1 сая төгрөгөөр арилжаалагджээ.


5-р сарын 3-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,386.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,393.27 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.80%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



\*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Зах зээлийн хураангуй

| Хураангуй             | Үнийн дүн /сая төг/ |
|-----------------------|---------------------|
| Арилжигдсан үнийн дүн | 3,303.6             |
| Зах зээлийн үнэлгээ   | 2,386,641.7         |

## Зах зээлийн индекс

| Индекс        | Хаалт     | Өөрчлөлт |
|---------------|-----------|----------|
| MSE Top 20    | 20,393.27 | 0.80% ▲  |
| MSE I индекс  | 9,446.83  | 4.63% ▲  |
| MSE II индекс | 8,011.23  | -1.52% ▼ |

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

| Компани         | Ширхэг    | Үнийн дүн /төг/ |
|-----------------|-----------|-----------------|
| Түмэн шувуут    | 4,683,059 | 936,642,886     |
| Мандал даатгал  | 18,858    | 101,198,415     |
| АПУ             | 164,620   | 98,499,095      |
| Говь            | 90,154    | 26,432,745      |
| Ард кредит ББСБ | 288,163   | 21,498,583      |

## Өсөлттэй хувьцаа

| Компани           | Хаалт /төг/ | Өөрчлөлт |
|-------------------|-------------|----------|
| МИК Холдинг       | 14,200.00   | 23.69% ▲ |
| Хөх ган           | 89.59       | 19.45% ▲ |
| Тав               | 13,500.00   | 11.85% ▲ |
| Жуулчин дүти фрий | 110,000.00  | 9.13% ▲  |
| Дархан нэхий      | 16,000.00   | 5.96% ▲  |

## Бууралттай хувьцаа

| Компани       | Хаалт /төг/ | Өөрчлөлт  |
|---------------|-------------|-----------|
| УБ-БҮК        | 315.00      | -17.11% ▼ |
| Хай би ойл    | 46.00       | -16.20% ▼ |
| Өндөрхаан     | 6,820.00    | -14.75% ▼ |
| Увс чацаргана | 385.00      | -14.12% ▼ |
| Ариг гал      | 3,240.00    | -10.00% ▼ |

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

| Компани             | Арилжааны үнийн дүн /төг/ |
|---------------------|---------------------------|
| Тэнгэр Капитал      | 4,000,167,130             |
| Голомт Капитал      | 1,930,547,596             |
| Апекс Капитал       | 108,430,015               |
| Ти Ди Би Капитал    | 86,337,634                |
| Стандарт Инвестмент | 82,987,135                |

## Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

| Компани      | Хаалт /төг/ | ЗЗҮ /сая.төг/ |
|--------------|-------------|---------------|
| АПУ          | 591.18      | 629,123       |
| Таван толгой | 6,195.00    | 326,261       |
| МИК          | 14,200.00   | 294,072       |
| Говь         | 296.71      | 231,467       |
| Сүү          | 206.84      | 71,153        |

## ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

| № | Үнэт цаасны нэр               | Арилжигдсан ширхэг | Үнийн дүн /төг/ | Доод /төг/ | Дээд /төг/ | 7 хоног | Хүү    |
|---|-------------------------------|--------------------|-----------------|------------|------------|---------|--------|
| 1 | ZGEB-BD-25/04/20-A0236-16.993 | 100                | 10,050,000      | 100,500    | 100,500    | 156     | 16.993 |
| 2 | ZGEB-BD-27/03/20-A0225-18     | 20,000             | 2,000,000,000   | 100,000    | 100,000    | 156     | 18.000 |

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

| №  | Симбол | Компанийн нэр                               | 2018 оны цэвэр ашиг /сая төг/ | Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/ | Ногдол ашиг төлөлтийн харьцаа | Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/ | Шийдвэр огноо | Бүртгэлийн өдөр | Хуваарилах өдөр      |
|----|--------|---------------------------------------------|-------------------------------|---------------------------------------|-------------------------------|----------------------------------|---------------|-----------------|----------------------|
| 1  | HRM    | Гермес центр ХК                             | 783.4                         | 298.5                                 | 38.1%                         | 3.8                              | 2019.01.25    | 2019.02.18      | 2019.03.18-нд олгов  |
| 2  | LEND   | ЛэндМН ББСБ                                 | 2,560.3                       | 800.0                                 | 31.2%                         | 1.0                              | 2019.01.30    | 2019.02.22      | 2019.03.28-нд олгов  |
| 3  | MBW    | Монгол Базальт ХК                           | 217.2                         | 56.4                                  | 26.0%                         | 1.0                              | 2019.02.01    | 2019.03.25      | 2019.10.01-с         |
| 4  | BTG    | Баянтээг ХК                                 | 1,771.4                       | 1,000.0                               | 56.5%                         | 3,958.7                          | 2019.02.11    | 2019.03.04      | 2019.06.01-с         |
| 5  | SUL    | Жуулчин дюти фрий ХК                        | 1,384.5                       | 653.6                                 | 47.2%                         | 10,000.0                         | 2019.02.12    | 2019.04.10      | 2019.05.31-с         |
| 6  | GOV    | Говь ХК                                     | 17,764.2                      | 5,304.8                               | 29.9%                         | 6.8                              | 2019.02.13    | 2019.03.28      | 2019.04.25-с         |
| 7  | ADU    | Хөвсгөл алтан дуулга ХК                     | 399.2                         | 1,888.1                               | 473.0%                        | 120.0                            | 2019.02.13    | 2019.04.01      | 2019.05.01-с         |
| 8  | TCK    | Талх чихэр ХК                               | 1,975.9                       | 204.7                                 | 10.4%                         | 200.0                            | 2019.02.14    | 2019.04.03      | 2019.07.01-с         |
| 9  | MMX    | Мах импекс ХК                               | 778.6                         | 456.1                                 | 58.6%                         | 120.0                            | 2019.02.14    | 2019.04.03      | 2019.10.01-с         |
| 10 | BUK    | УБ-БҮК ХК                                   | 566.4                         | 131.5                                 | 23.2%                         | 1.0                              | 2019.02.14    | 2019.04.05      | 2019.05.01-с         |
| 11 | ТАН    | Тахь-ко ХК                                  | 799.1                         | 128.5                                 | 16.1%                         | 108.0                            | 2019.02.15    | 2019.04.05      | 2019.04.24-нд олгов  |
| 12 | BNG    | Баянгол зочид буудал ХК                     | 3,433.1                       | 150.2                                 | 4.4%                          | 355.0                            | 2019.02.16    | 2019.04.05      | 2019.09.01-с         |
| 13 | MNP    | Монгол шуудан ХК                            | 1,560.3                       | 468.1                                 | 30.0%                         | 4.7                              | 2019.02.18    | 2019.04.05      | 2019.05.01-с         |
| 14 | HRD    | Хүрд ХК                                     | 751.1                         | 74.4                                  | 9.9%                          | 550.0                            | 2019.02.18    | 2019.03.04      | 2019.06.01-ний дотор |
| 15 | MNDL   | Мандал даатгал ХК                           | 3,868.3                       | 624.3                                 | 16.1%                         | 100.0                            | 2019.02.18    | 2019.04.10      | 2019.05.01-с         |
| 16 | GTL    | Гутал ХК                                    | 2,225.8                       | 1,257.7                               | 56.5%                         | 777.0                            | 2019.02.18    | 2019.03.13      | 2019.05.06-с         |
| 17 | TEX    | Техник импорт ХК                            | 2,702.0                       | 723.4                                 | 26.8%                         | 500.0                            | 2019.02.18    | 2019.03.11      | 2019.04.11-с         |
| 18 | APU    | АПУ ХК                                      | 57,851.7                      | 48,952.4                              | 84.6%                         | 46.0                             | 2019.02.19    | 2019.04.04      | 2019.12.31-ний дотор |
| 19 | AIC    | Ард даатгал ХК                              | 1,263.4                       | 631.8                                 | 50.0%                         | 25.3                             | 2019.02.19    | 2019.03.15      | 2019.06.29-ний дотор |
| 20 | GHC    | Ган хийц ХК                                 | 20.3                          | 12.1                                  | 59.7%                         | 50.0                             | 2019.02.19    | 2019.03.22      | 2019.10.01-с         |
| 21 | HUV    | Хөвсгөл геологи ХК                          | 107.4                         | 14.4                                  | 13.4%                         | 100.0                            | 2019.02.19    | 2019.04.03      | 2019.04.29-с         |
| 22 | HNS    | Хөвсгөл хүнс ХК                             | 11.3                          | 2.6                                   | 23.4%                         | 10.0                             | 2019.02.19    | 2019.04.03      | 2019.05.15-с         |
| 23 | TAL    | Талын гал ХК                                | 255.9                         | 34.7                                  | 13.6%                         | 50.0                             | 2019.02.25    | 2019.03.26      | N/A                  |
| 24 | BRC    | Барилга корпораци ХК                        | 1,311.0                       | 40.1                                  | 3.1%                          | 985.0                            | 2019.02.26    | 2019.03.18      | 2019.03.18           |
| 25 | UBH    | Улаанбаатар хивс ХК                         | 235.6                         | 48.6                                  | 20.6%                         | 120.0                            | 2019.02.26    | 2019.03.18      | 2019.05.31-ний дотор |
| 26 | DSS    | Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК | 11.5                          | 11.4                                  | 99.2%                         | 1.1                              | 2019.03.01    | 2019.03.21      | 2019.07.02-с         |
| 27 | ADL    | Адуунчулуун ХК                              | 547.1                         | 409.7                                 | 74.9%                         | 130.0                            | 2019.03.11    | 2019.04.03      | 2019.12.31-ний дотор |
| 28 | TEE    | Тээвэр дархан ХК                            | 22.3                          | 81.7                                  | 365.5%                        | 500.0                            | 2019.04.17    | 2019.03.27      | 2019.12.31-ний дотор |
| 29 | ERS    | Монгол алт ХК                               | 6.3                           | 39.9                                  | 631.2%                        | 150.0                            | 2019.04.17    | 2019.03.27      | 2019.12.31-ний дотор |
| 30 | TTL    | Таван толгой ХК                             | 52,858.1                      | 44,923.4                              | 85.0%                         | 853.0                            | 2019.04.26    | 2019.04.01      | 2019.05.03-ны дотор  |
| 31 | EER    | Ариг гал ХК                                 | 449.3                         | 109.4                                 | 24.3%                         | 32.5                             | 2019.04.26    | 2019.03.27      | 2019.09.30-ны дотор  |

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**“Монос хүнс” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааны захиалга нийлүүлэлтээсээ давж хаагдлаа**

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн эрүүл мэндийн салбарын анхны IPO болох “Монос Хүнс” ХК нь нийт хувьцааны 30 хувь буюу 122,655,128 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2019 оны 4-р сарын 22-оос 2019 оны 5-р сарын 3-ны өдрийн 10:00-17:00 цаг хүртэл авч дууслаа.

“Монос Хүнс” ХК-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад 3,976 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 87,982,368 ширхэг худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнгээс 21.7 хувиар давсан үзүүлэлт боллоо.

“Монос Хүнс” ХК-ийн үнэт цаас худалдан авах захиалгуудын хуваарилалтын тайланг 2019 оны 5-р сарын 6-ны өдөрт багтаан СЗХ-нд хүргүүлэх бөгөөд СЗХ-оос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх шийдвэрийг гаргасан үед хөрөнгө оруулагч нар тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөрийн үлдэгдэл мөнгөн хөрөнгийг буцаан авах эрх үүсэх юм.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

**“Баялаг сүмбэр” ХК-ийн хувьцааг худалдан авах тендер санал гаргалаа**

“Хөхөө Агротех” ХХК нь “Баялаг Сүмбэр” ХК-ийн хяналтын багцыг худалдан авсан тул Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтын дагуу бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах тендер санал гаргалаа.

Санал болгож буй үнэ: 3 төгрөг

Санал гаргагчийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг: 64,661 буюу 89.6 хувь

Худалдан авах тоо ширхэг: 7,496 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2019.04.29

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2019.05.29

Хувьцааны худалдан авах төлбөрийн хугацаа: 2019.05.30

Санал хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Сити центр 1003 тоот

Дэлгэрэнгүй мэдээллийг 88043898 утсаар авна уу.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

**“Таван толгой” ХК ногдол ашиг тараахаар**

“Таван толгой” ХК нь 2019 оны 4-р сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №04 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 853 төгрөг буюу нийт 44.9 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны 4-р сарын 1-ний өдрөөр гаргаж, ногдол ашгийг компанийн байранд болон “ҮЦТХТ” ТӨХК дэх хувьцаа эзэмшигчдийн дансанд 2019 оны 5-р сарын 3-ны өдрийн дотор шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж




**“Инвескор ББСБ” компани нээлттэй хувьцаат компани боллоо**

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 3-р сарын 26-ны өдрийн А/23 тоот тушаалаар “Инвескор ББСБ” ХК-ийн нийт 71,727,918 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн III ангилалд бүртгэснийг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 4-р сарын 24-ний өдрийн хурлаар хэлэлцэж, 70 тоот тогтоолоор нийт гаргасан хувьцааны 15 хувь буюу 10,759,188 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд МХБ-ийн “Арилжааны журам”-ын дагуу захиалга бүртгэлийн аргаар санал болгон арилжаалахыг зөвшөөрлөө.

Тус компани санал болгон худалдах хувьцааны 85 хувь буюу 9.1 сая ширхэгийг тус бүрийг нь 1,650-1,750 төгрөгөөр стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдсэн 15 хувь буюу 1.6 сая ширхэгийг тус бүрийг нь 1,550-1,650 төгрөгөөр нийтэд санал болгон худалдах замаар нийт 17.6-18.7 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байна.

Энэхүү хувьцааны андеррайтингийн үйлчилгээг “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК, аудитын үйлчилгээг “БДО Аудит” ХХК, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг “Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээг “Гэрэгэ Эстимэйт” ХХК тус тус үзүүлж байна.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж



**“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” мэдээлэл ирүүлээ**

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (TSX:ERD | MSE:ERDN)-ийг үүсгэн байгуулагдсанаас хойш Санхүү хариуцсан захирлын албыг хашиж байсан Кэннэт МакДоналд нь 2019 оны 5-р сарын 1-нд тэтгэвэрт гарсантай холбогдуулан түүний оронд Санхүү хариуцсан захирлаар Роберт Женкинсийг томилсон байна.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

**“Мандал даатгал” ХК нэгж хувьцаа тус бүрийг 100 хуваана**

Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Мандал даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болж өнгөрлөө. Хуралд компанийн 6.2 сая ширхэг хувьцааг эзэмшиж буй 818 хувьцаа эзэмшигчээс 86 хувь нь оролцсон байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Мандал даатгал” ХК-ийн нэгж хувьцаа тус бүрийг 100 хуваах саналыг 86 хувийн саналаар зөвшөөрчээ. Ингэснээр тус компани 624,301,600 ширхэг хувьцаатай болох юм байна.

“Мандал даатгал” ХК 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 100 төгрөг буюу нийт 624.3 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилаад байгаа юм. Даатгал, давхар даатгал, тэтгэврийн санхүүжилтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тус компани өнгөрсөн оны 5-р сарын 7-ны өдөр Монголын Хөрөнгийн биржид бүртгүүлсэн юм. Тухайн үед зах зээлд нийт 6.2 сая ширхэг хувьцаа гаргаж байв.

Мягмар гарагт МХБ-ийн 20 удаагийн хэлцлээр тус компанийн 2,833 ширхэг хувьцаа арилжигдж, нэгж хувьцааны ханш нь 0.28 хувиар өсжээ. Тус компанийн хувьцаа МХБ дээр идэвхтэй арилжигддаг хувьцаануудын нэг юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### IV сард алт тушаалт өмнөх оноос 10 хувиар өсөв

Монголбанк 4-р сард 1.1 тонн алт худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс 10 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Мөн өнгөрсөн сард Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 9 кг алт, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 3 кг алт худалдан авчээ.

Алт худалдан авалт өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаа нь Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, алтны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 5 хувь болгосонтой холбоотой гэж Төв банк тайлбарлалаа. Хуулийг 2019 оны 4-р сарын 8-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн байна. Хуулийн тодорхойгүй байдалтай буюу оны эхний гурван сард алт тушаалт огцом буураад байсан юм. Тайлант сард Монголбанкны нэг грамм алт худалдан авах дундаж үнэ 108.7 мянган төгрөг байжээ.

Энэ оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлд гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх чиглэл багтсан юм. Энэ хүрээнд гадаад валютын улсын нөөцийг дунд хугацаанд хамгийн багадаа 6.5 тэрбум ам.доллар хүргэх шаардлагатай гэж үзэж байна. 2018 онд Монголбанк 22 тонн алт худалдаж авсан нь өмнө нь байгаагүй өндөр үзүүлэлт болсон юм. Алт худалдан авалтаас өнгөрсөн онд 700 гаруй сая ам.долларыг валютын нөөцөд бүрдүүлжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



### УУХҮЯ: Газрын тос боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн ажлын явц 80 хувьтай байна

5-р сарын байдлаар шатахууны хилийн үнэ тонн тутамдаа өмнөх сараас А-80, АИ-92 автобензин 53 ам.доллараар, дизель түлш 17 ам.доллараар өссөн нь дотоодын шатахууны үнэ өсөхөд нөлөөлж байна гэж Ашигт малтмал, Газрын тосны газар мэдээллээ.

Ираны хориг арга хэмжээнээс шалтгаалан газрын тосны ханш сүүлийн зургаан сарын дээд түвшинд хүрээд байгааг мөн онцолсон юм. Олон Улсын Валютын Сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд шатахууны үнийг автоматаар тогтоох механизмыг нэвтрүүлэх ажлын хэсэг өнгөрсөн сард Монгол Улсад ажилласан байна. Энэ нь үнийн огцом хэлбэлзлийг бууруулж, зах зээлийн зарчимд нийцүүлэх ач холбогдолтой гэж үзэж байгаа аж.

Үүнээс гадна дотоодод газрын тос боловсруулах 1.5 сая тонны хүчин чадалтай үйлдвэр барих төслийн дэд бүтцийн ажил 80 хувьтай, графикийн дагуу явж байгаа юм байна. Газрын тосны үйлдвэрийг түүхий эдээр хангахын тулд эрэл хайгуулыг эрчимжүүлж, нөөц өсгөж, олборлолтоо нэмэгдүүлэх шаардлага үүсжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



### "Эрдэнэс Тавантолгой" компани зардлаа 400 тэрбум төгрөгөөр бууруулна

"Эрдэнэс Тавантолгой" компани энэ оны эхний улиралд 304 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Тус компани эхний улиралд 4.2 сая тонн нүүрс олборлож, 2.4 сая тонныг экспортолсон байна. Үүнээс 741 тэрбум төгрөгийн орлого олж, 193.5 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлжээ. Энэ талаар "Эрдэнэс Тавантолгой" компанийн Гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, "Манай компани өнгөрсөн онд 1.99 их наяд төгрөгийн борлуулалтын орлого олсноос татвар болон зардлаа хасаж тооцвол, 807.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, УИХ, Засгийн газрын шийдвэрийн дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2018 оны цэвэр ашгаар дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх болсон. Тухайлбал, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр зам, Нүүрс баяжуулах үйлдвэр, Усан хангамж, Конвейерийн систем, Хими технологийн үйлдвэр, Цахилгаан станц зэрэг төслийн анхны хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхээр шийдвэрлээд байна. Үүнтэй холбоотойгоор компани төсөвтөө тодотгол хийж, оффисын барилга, автомашин, компьютер тоног төхөөрөмж худалдан авах зэрэг хөрөнгө оруулалтын зардлаа 400 тэрбум төгрөгөөр бууруулах шийдвэр гаргасан" гэлээ.

УИХ, Засгийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу олон улсад IPO гаргах бэлтгэл эрчимтэй хийж байгаа бөгөөд Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай холбоотойгоор олон улсын зөвлөх шалгаруулахтай холбоотой зарим ажил түр хойшилжээ. Харин иргэдийн мэдээллийн нэгдсэн бааз бүрдүүлэх, бичиг баримт боловсруулах ажлын биелэлт сайн байгааг мөн дурдав.

Засгийн газраас энэ оны 5-р сарын 1-ээс эхлэн нийслэл рүү түүхий нүүрс оруулахыг хориглосон. Тиймээс 5 сарын 15-аас эхлэн "Тавантолгой түлш" компанийн сайжруулсан түлшийг иргэдэд нийлүүлэх юм. Уг ажлын бэлтгэл 90 орчим хувьтай байгааг "Эрдэнэс Тавантолгой" компанийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг онцлов. Тэрбээр, "Тавантолгой түлш" компани жилд 800 мянган тонн түлш үйлдвэрлэнэ. Энэ түлшийг хэрэглэснээр 2019-2020 онд Улаанбаатар хотын утаа 50-60 хувиар буурах юм. Тавантолгойн түлшийг өмнөх сайжруулсан түлштэй харьцуулшгүй. Гал түлэхэд эхний 10-15 минут утаа гарна. Түүнээс хойш ямар ч утаа гарахгүй. Дээр нь хүний биед хоргүйг 24 төрлийн шинжилгээгээр тогтоосон" гэлээ.

Эх сурвалж: Montsame.mn

### мэдэгдэл

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.